



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/159

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.9 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.8, 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Наадмын талбайн засвар, 2 давхар болгох, наадмын талбай руу тог татах ажлыг гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: Ж.Чимэддулам (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Нарийн бичгийн дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Ч.Батдулам (Нягтлан бодогч)

Б.Пүрэвсүрэн Нягтлан бодогч)


М.Батсүх (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
төлөөлөгч)

Ж.Хүнийхүн (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
төлөөлөгч)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Орон нутгийн өмчид бүртгэх шаардлагатай хөрөнгийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

022301235